



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/162/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Төлбөрийн акт.....	14
4.2 Албан шаардлага	14
4.2 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

АУА 02 15 № 2/70

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй худалдан авсан хүнсний тайланг нярав тайлан гаргасан байхад Нягтлан бодогч нь санхүүгийн программд бараа материалыг бүртгээгүй, мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардалд бүртгэсэн байна.
- Санхүүгийн тайлан, няравын тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6

D- alban bichig 2022 A4 TOOT

005020387

дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.20 "Төсөвт байгууллага нь бараа материалыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа байнгын системийн аргыг ашиглана" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Үнэлгээ ба хуваарилалт", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,737,672.80	60,911,696.83
35	БАРАА МАТЕРИАЛ	42,737,672.80	60,911,696.83
351	Түүхий эд материал	10,326,639.30	17,937,701.30
35110	Тусгай зориулалттай материал	9,515,639.30	14,376,801.30
35130	Эм боох материал	811,000.00	3,560,900.00
354	Хангамжийн материал	32,411,033.50	42,973,995.53
35410	Бичиг хэргийн материал	20,240.00	3,000.00
35420	Аж ахуйн материал	174,000.00	45,000.00
35460	Хүнсний материал	1,069,600.00	1,793,102.03
35470	Бусад хангамжийн материал	31,147,193.50	41,132,893.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	794,544,492.70	791,987,758.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	794,544,492.70	791,987,758.20
392	Биет хөрөнгө	737,060,492.70	734,503,758.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	731,118,262.98	731,118,262.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,239,342.00	-45,174,060.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,939,491.85	50,714,491.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32,739,644.54	-35,203,403.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,137,514.92	68,637,514.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,313,229.94	-40,721,962.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,888,740.00	11,062,240.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,731,300.57	-5,929,325.59
393	Биет бус хөрөнгө	57,484,000.00	57,484,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	58,254,000.00	58,254,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	837,282,165.50	852,899,455.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	837,282,165.50	852,899,455.03
51	Засгийн газрын хувь оролцоо	837,282,165.50	852,899,455.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,346,782,150.50	1,346,782,150.50
51101	Өмч: - төрийн	1,346,782,150.50	1,346,782,150.50
512	Хуримтлагдсан үр дүн	-509,499,985.00	-493,882,695.47
51210	Өмнөх үеийн үр дүн	-509,499,985.00	-509,499,985.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	15,617,289.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	837,282,165.50	852,899,455.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	451,536,602.00	424,727,872.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,384,662.00	7,846,162.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,384,662.00	7,846,162.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,384,662.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,384,662.00	00.00
120010	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		2,275,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		5,571,162.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	439,151,940.00	423,965,340.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	368,894,600.00	353,708,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	368,894,600.00	353,708,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,614,540.00	7,755,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	7,755,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,614,540.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,642,800.00	55,418,710.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,642,800.00	55,418,710.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	443,701,989.03	409,110,582.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	443,701,989.03	409,110,582.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,880,302.90	391,098,451.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,359,784.78	255,219,887.83
210101	Үндсэн цалин	217,133,086.00	213,812,803.38
210102	Нэмэгдэл	30,765,044.46	20,415,778.80
210104	Урамшуулал	24,107,692.00	20,991,305.65
210105	Гэрээт ажлын хөлс	1,353,962.32	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,808,979.09	32,301,830.75
210201	Тэтгэврийн даатгал	18,259,437.11	21,697,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,686,300.00	2,689,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,149,000.00	2,151,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	344,804.89	537,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,369,437.09	5,225,730.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,543,710.00	54,918,710.00
210301	Гэрэл, цахилгаан	2,684,900.00	2,308,950.00
210302	Түлш, халаалт	37,039,110.00	37,021,530.00
210303	Цэвэр, бохир ус	16,819,700.00	15,588,230.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,776,220.60	6,177,390.00
210401	Бичиг хэрэг	565,960.00	1,470,240.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	941,200.00	1,092,400.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	555,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	935,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,320,500.00	1,195,900.00
210408	Бараа материал акталсны зардал	1,338,260.60	00.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	00.00	363,350.00
2105	Нормативт зардал	30,585,430.00	11,372,797.97
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,713,600.00	1,567,700.00
210502	Хоол, хүнс	28,556,630.00	9,805,097.97
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	315,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,230,900.00	2,015,900.00

210604	Урсгал засвар	11,230,900.00	2,015,900.00
2107	Томилолт, зочны зардал	140,600.00	115,300.00
210702	Дотоод албан томилолт	140,600.00	115,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	941,400.00	8,801,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	641,400.00	8,211,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,493,278.43	20,175,234.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,170,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,207,800.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,285,478.43	19,005,234.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,821,686.13	18,012,131.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,765,140.00	2,523,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,614,540.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,600.00	2,523,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,099,090.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,099,090.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,957,456.13	15,488,631.42
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,957,456.13	15,488,631.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,834,612.97	15,617,289.53
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	7,834,612.97	15,617,289.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	439,151,940.00	416,881,710.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	439,151,940.00	416,881,710.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	368,894,600.00	353,708,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	368,894,600.00	353,708,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,614,540.00	7,755,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	7,755,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,614,540.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,642,800.00	55,418,710.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,642,800.00	55,418,710.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	424,031,940.00	402,708,210.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	424,031,940.00	402,708,210.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	414,210,253.87	384,696,078.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,834,206.78	255,219,887.83
210101	Үндсэн цалин	216,027,100.00	213,812,803.38
210102	Нэмэгдэл	30,765,044.46	20,415,778.80
210104	Урамшуулал	19,688,100.00	20,991,305.65
210105	Гэрээт ажлын хөлс	1,353,962.32	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,575,037.09	32,301,830.75
210201	Тэтгэврийн даатгал	23,025,495.11	21,697,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,686,300.00	2,689,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,149,000.00	2,151,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	344,804.89	537,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,369,437.09	5,225,730.75

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,543,710.00	54,918,710.00
210301	Гэрэл, цахилгаан	2,684,900.00	2,308,950.00
210302	Түлш, халаалт	37,039,110.00	37,021,530.00
210303	Цэвэр, бохир ус	16,819,700.00	15,588,230.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,556,000.00	9,098,300.00
210401	Бичиг хэрэг	550,500.00	661,100.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	941,200.00	1,092,400.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	555,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	935,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,454,000.00	5,289,300.00
2105	Нормативт зардал	29,430,600.00	16,553,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,720,300.00	607,600.00
210502	Хоол, хүнс	26,395,100.00	10,891,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	315,200.00	5,053,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,230,900.00	2,015,900.00
210604	Урсгал засвар	11,230,900.00	2,015,900.00
2107	Томилот, зочны зардал	140,600.00	115,300.00
210702	Дотоод албан томилот	140,600.00	115,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	941,400.00	8,985,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	641,400.00	8,395,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,957,800.00	5,487,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	4,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,957,800.00	987,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,821,686.13	18,012,131.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,765,140.00	2,523,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,614,540.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,600.00	2,523,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,099,090.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,099,090.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,957,456.13	15,488,631.42
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,957,456.13	15,488,631.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,120,000.00	14,173,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,120,000.00	14,173,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,120,000.00	14,173,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,120,000.00	14,173,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,120,000.00	14,173,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-15,120,000.00	-14,173,500.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,346,782,150.50	-500,434,810.08	846,347,340.42
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,346,782,150.50	-500,434,810.08	846,347,340.42
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-11,218,181.45	-11,218,181.45
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,346,782,150.50	-509,499,985.00	837,282,165.50
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,346,782,150.50	-509,499,985.00	837,282,165.50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,346,782,150.50	-509,499,985.00	837,282,165.50
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	15,617,289.53	15,617,289.53
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,346,782,150.50	-493,882,695.47	852,899,455.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	417,150,800.00	393,638,078.58	23,512,721.42	94.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,150,800.00	393,638,078.58	23,512,721.42	94.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	414,627,300.00	391,114,578.58	23,512,721.42	94.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,923,300.00	255,219,887.83	8,703,412.17	96.7
210101	Үндсэн цалин	218,449,400.00	213,812,803.38	4,636,596.62	97.9
210102	Нэмэгдэл	24,431,500.00	20,415,778.80	4,015,721.20	83.6
210104	Урамшуулал	21,042,400.00	20,991,305.65	51,094.35	99.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,454,500.00	32,301,830.75	152,669.25	99.5
210201	Тэтгэврийн даатгал	21,697,700.00	21,697,700.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,689,200.00	2,689,200.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,151,300.00	2,151,300.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	537,900.00	537,900.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,378,400.00	5,225,730.75	152,669.25	97.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,942,800.00	54,918,710.00	8,024,090.00	87.3
210301	Гэрэл, цахилгаан	5,084,900.00	2,308,950.00	2,775,950.00	45.4
210302	Түлш, халаалт	40,653,900.00	37,021,530.00	3,632,370.00	91.1
210303	Цэвэр, бохир ус	17,204,000.00	15,588,230.00	1,615,770.00	90.6
2104	Хангамж, бараа материалын зардал	9,154,500.00	9,098,300.00	56,200.00	99.4
210401	Бичиг хэрэг	661,100.00	661,100.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,092,400.00	1,092,400.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	611,700.00	555,500.00	56,200.00	90.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	500,000.00	500,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,289,300.00	5,289,300.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	23,129,600.00	16,553,250.00	6,576,350.00	71.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	607,600.00	607,600.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	17,468,300.00	10,891,950.00	6,576,350.00	62.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,053,700.00	5,053,700.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,189,400.00	16,189,400.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0
210602	Тавилга	6,500,000.00	6,500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	5,189,400.00	5,189,400.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	115,300.00	115,300.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	115,300.00	115,300.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,230,000.00	1,230,000.00	0.00	100.0

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчлэг	640,000.00	640,000.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5487900.00	5487900.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	987,900.00	987,900.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,523,500.00	2,523,500.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,523,500.00	2,523,500.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,523,500.00	2,523,500.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	417,150,800.00	393,638,078.58	23,512,721.42	94.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	353,708,000.00	338,219,368.58	15,488,631.42	95.6
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	353,708,000.00	338,219,368.58	15,488,631.42	95.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	63,442,800.00	55,418,710.00	8,024,090.00	87.4
132001	Орон нутгийн төсвөөс	63,442,800.00	55,418,710.00	8,024,090.00	87.4
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	0.00	0.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	0.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00	0.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00	0.00	0.00
650004	СББ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00	0.00	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	0.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		7,755,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,755,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,755,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,755,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,755,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	7755000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		7,755,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,755,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг эрхлэгч Э.Оюунтуяа, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Ц.Занабаяр нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хүүхэд болон багшийн хөгжлийг дэмжих, эрүүл аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчныг бүрдүүлж, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг хангах, үйлчлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 442,247.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,633.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,643.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 4,295.7 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,617.3 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал болон үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,737.7	60,911.7	18,174.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	42,737.7	60,911.7	18,174.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	794,544.5	791,987.8	(2,556.7)
Үндсэн хөрөнгө	903,338.0	919,786.5	16,448.5
Хуримтлагдсан элэгдэл	(108,793.5)	(127,798.8)	(19,005.2)
Нийт хөрөнгө	837,282.2	852,899.5	15,617.3
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	837,282.2	852,899.5	15,617.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	837,282.2	852,899.5	15,617.3

Бараа материалын дансны үлдэгдэл 60,911.7 мянган төгрөг болж 18,174.0 мянган төгрөгөөр өссөн нь, тусгай зориулалтын материал 4,861.2 мянга, эм боох материал 2,749.9 мянга, хүнсний материал 723.5 мянга, бусад хангамжийн материал 9,985.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн тусгай зориулалтын материал дээр БСШУЯ-аас 4,861.2 мянган төгрөгийн эд материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, урсгал төсвийн худалдан авалтаар

бусад хангамжийн материал дээр 10,724.8 мянган төгрөгийн материал худалдан авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 919,786.5 мянган төгрөг болж 16,448.5 мянган төгрөгөөр өссөн нь БСШУЯ-аас 2275.0 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр, урсгал төсвийн худалдан авалтаар 14,173.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 852,899.5 мянган төгрөг болж 15,613.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 15,613.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 549,344.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 549,344.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 99,170.4 мянган төгрөгөөр бууруулж 450,174.5 мянган төгрөгөөр анх баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1 удаа тодотгож, 417,150.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 353,708.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 63,442.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 353,708.0 мянга, орон нутгийн төсвөөс 55,418.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 15,488.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 393,638.1 мянган төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 8,703.4 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 152.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 8,024.1 мянга, хангамж, бараа материалын зардлыг 56.2 мянга, нормативд зардлыг 6,576.4 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2020-2021 оны хичээлийн жилд нийт 25 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, нийт 6 бүлэг, 162 хүүхэд хүмүүжиж байгаа бөгөөд 2021 оны үйл ажиллагааны зардалд 417,150.8 мянган төгрөг батлагдсан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Г.Ганчимэг санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 4 зорилтын хүрээнд 121 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 409,110.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 34,594.4 мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж нь өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, нормативд зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Тус байгууллага нь Ковид19 цар тахалтай холбоотойгоор постод эргүүлд гарсан төрийн албан хаагчдад хоол бэлтгүүлэхээр тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 7755.0 мянган мөнгийг шилжүүлсэн байна. Худалдан авсан хүнсний тайланг нярав тайлан гаргасан байхад Нягтлан бодогч нь санхүүгийн программд бараа материалыг бүртгээгүй, мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардалд бүртгэсэн байна. Энэ зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй учир хязгаарлалттай дүгнэлт өгсөн болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 706,975.6 мянган төгрөгийн 49 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийг 3 дугаар улирал, 6.4.5-д заасан орлогын 29,167.2 мянган төгрөгийн 2 гүйлгээг тус тус хугацаа хоцроож, 6.4.3-д заасан тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх 38,051.3 мянган төгрөгийн 3 мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- 2021 оны төсвийг анх 450,174.5 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 33,023.7 мянган төгрөг бууруулан баталснаас 353,708.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 63,442.8 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тодотгон баталсан бөгөөд 15,488.6 мянга төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 3.7 хувийг хэмнэсэн гэж үзэхээр байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1¹ гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 66142.8 мянган төгрөгөөр, тодотголоор 63,442.8 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 54,918.7 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 11,224.1 мянган төгрөг буюу 17.0 хувь хэмнэсэн.

- Бичиг хэргийн зардлыг 661.1 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.9²-д заасантай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 62,195.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13,055.6 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 2,423.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 33,558.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгч, 13,158.1 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,042.8 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 116.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7,755.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1,170.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Төлбөрийн акт

1. Хоол хүнсний зардлыг тулгахад анхан шатны баримтгүй 116.9 төгрөгийг зарлага гаргасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй зарцуулсан 116.9 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.2 Албан шаардлага

1. Тайлант хугацааны Ковид-19 цар тахалтай холбоотойгоор пост эргүүлд гарсан төрийн албан хаагчдад хоол бэлтгүүлэхээр тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 7755.0 мянган мөнгийг шилжүүлсэн байна. Худалдан авсан хүнсний тайланг

1. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах

2. бичиг хэрэг, албан хэрэг хөтөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах.

нярав тайлан гаргасан байхад Нягтлан бодогч нь санхүүгийн программд бараа материалыг бүртгээгүй, мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.20 “Төсөвт байгууллага нь бараа материалыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа байнгын системийн аргыг ашиглана” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд худалдан авсан бүртгээгүй хүнсний материалыг санхүүгийн программд орлого, зарлагын гүйлгээг бүрэн бүртгэж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийг 3 дугаар улирал, 6.4.5-д заасан орлогын 29,167.2 мянган төгрөгийн 2 гүйлгээг тус тус хугацаа хоцроож, 6.4.3-д заасан тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч 38,051.3 мянган төгрөгийн 3 мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар “6.1.2 хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.4.3 “Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д заасан заасан үнийн дүн бүхий 38,051.3 мянган төгрөгийн 3 мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, албан шаардлага өгөв.

4.2 Зөвлөмж

1. Тайлант хугацааны бараа материалын тайланг тулгахад нярвын тайлан санхүүгийн тайлангаас нийт 509.8 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид нярвын тайланг сар бүр хянаж, хүлээн авч, анхан шатны баримтад үндэслэн санхүүгийн тайланг гаргаж байх .

2. 2021 оны төсвийг анх 450,174.5 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 33,023.7 мянган төгрөг бууруулан баталснаас 353,708.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 63,442.8 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр

тодотгон баталсан бөгөөд 15,488.6 мянга төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, нийт зардлын 3.7 хувийг хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 гэсэн заалттай нийцэхгүй байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг анх баталснаас 17.0 хувиар хэмнэсэн ч, бичиг хэргийн зардалд хэмнэлт гаргаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.1³, 1.9⁴ гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэг	5	9042.8	0	0	1	116.9	2	7755.0	2	1170.9

_____ оОо _____

_____ оОо _____

3. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, үрсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах

4. Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах